

БАРИМТ, ҮЙЛ ЯВДАЛ

Гаалийн татвар гурав дахин нэмэгдсэн учир үнийн өсөлт буурахгүй байна гэв

»Турүүч нь / нүүрт»

Тэгсэн Консул хэлэхдээ анхнаасаа манайхны тавьсан саналаар наймаас дээш хүний суудалтай гэсэн санал л тавьсан болохоос биш таван суудалтай, бага оврын тээврийн хэрэгслийн асуудлыг өр хөндөөгүй шүү гэсэн. Үнэнээ л хэлж байх шиг байна лээ. Дарга нар нь бүх шатандаа асуудлыг тавиад яриад байгаа ч газар дээр нь хөөцөлдөх ёстой хүн нь Эрэн дэх консул Т.Мөнхгэрэл гэдэг хүн. Гэхдээ наад асуудлыг чинь одоо гаргаж тавиад, хөөцөлдөөд явж байгаа. Эрээний захиргаанаас үүнийг хүлээн зөвшөөрсөн. Дээрээс шийдвэр ирэхийг хүлээж байна гэсэн хариулт өгсөн.

- Жижиг тээврийн хэрэгсэл явснаар гарах үр өгөөж нь юу вэ?

Одоо зорчигчийн урсгал нэмэгдэж байгаа. Анх 300 зорчигч өдөр бүр явна гэж байсан шүү дээ. Түүндээ тааруулж автобусууд явуулж байна. Тэр нь ачааллаа даахгүй. Өнгөрсөн амралтын өдрүүдэд гарах хүмүүсийн урсгал нэмэгдээд, хятад талдаа ч мөн наашаа орох урсгал нэмэгдэж, шагийн үнээр автобусны билетийг борлуулж эхэлсэн. Билетийн үнэ 200, 250 юань хүрээд шаглагдах боллоо. Хятадууд нь түүндээ бүр гарчихсан. Сая нэг хэсэг нэг ширхэг билет 250 юанд хүрлээ. Өмнө нь өдөрт 1000 жижиг тээврийн хэрэгсэл, дээрээс нь өнөөдөр явж байгаа энэ автобусууд бүгд яваад энэ ачааллыг тэнцүүлдэг байсан шүү дээ. Үүнд бас нэг ялгаатай зүйл бий. Энгийн иргэдийн жижиг тээврийн хэрэгсэл явахгүй байгаа мөртлөө өдөрт хэд хэдэн хувийн машинууд орж гараад байгаа. Энэ юуны машин бэ гэхээр тайлбар



өгөх газар байхгүй. Мэдэхгүй, бид оруулаагүй гээд булзааруулдаг. Бид ингэж чөлөөтэй орж гараад байгаа жижиг машины дугаар болон бүртгэлийг авто тээврийн газраас авч өгөөч гэж Хил хамгаалах газарт хандсан, яриад байж байна. Тэгэхгүй бол мэдээлэлд ойрхон, дарга цэргийн машин өглөө болгон 150 юаниар нэг хүнийг бодоод зөөгөөд байдаг. Энгийн иргэд нь өөрсдийн машинаараа орж гарч чадахгүй байдалтай удлаа.

- Ерөнхийлөгч хил гаалиар ажиллалаа гэж байсан. Наагуур чинь очиход асуудлаа ярьж чадсан уу?

- Нэгдүгээрт, манай боомтын сайдтай болсон, тийм үү. Гадаад харилцааны сайд, Боомтын сайд гэж байж байна. Дээрээс нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд байна. Аймгийн иргэдийн хурал, засаг дарга гэх мэт. Энэ нүсэр том бүтэц байгаа мөртлөө иймэрхүү жижиг асуудлаа шийдэж чадахгүй байна, Монгол Улс. Ерөнхийлөгч нь, боомтын сайдтайгаа ирсэн. Ирээд иргэдтэйгээ уулзахгүй өөрсдийн маршрутаар

яваад "Өө энд чинь ёстой гоё барилга барьчихсан юм байна шүү дээ" гэж хэлчихээд л явчихсан. Тэр барилгаар чинь дамжаад энгийн ард иргэд, за бид бүр болье гэхэд хил орчмоор бизнес эрхэлдэг хүмүүс өөрийнхөө машиныг унаад, хил гаалиар чөлөөтэй зорчиж, өмнөх шигээ л явдаг болмоор байна шүү дээ. Бүх том бүтэц нь байгаа мөртлөө жижиг асуудлаа шийдэж чадахгүй байна. Иймэрхүү байдалтай л байна даа.

- Тээврийн ханш буураад байхад өргөн хэрэглээний барааны үнэ буурахгүй байгаа нь юутай холбоотой юм бол?

- Тээврийн зардал буурсан ч гаалийн татвар нэмэгдсэн. Энэ нь үнийн бууралтад тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа байх гэж жолооч нар ярьж байна лээ. Би Замын Үүдийн жолооч нарын группт ачаа тээврийн үнэ ханш буугаад ковидын өмнөх үедээ очихоод байхад өргөн хэрэглээний барааны үнэ яагаад буухгүй байна гэхэд "Гаалийн татвар ковидын өмнөх үеэс гурав дахин нэмэгдсэн, үнээ хэзээ ч буулгахгүй бодлого барьж

байна" гэж жолооч нар бичсэн байсан. Түүнээс гадна олон зүйл нөлөөлж л байгаа байх.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ачаа барааны үнийн талаар тодруулаа.

"2023 онд өссөн дүнгээр 5103 тээврийн хэрэгслээр 113,620.6 тн бараа материал орж ирсэн. 168 тээврийн хэрэгслээр 8909.6 тн нүүрс тээвэрлэсэн. 970 тээврийн хэрэгслээр 445,535.4 тн ачаа экспортолсон байна. Ачааны үнийн хувьд Эрэн-Улаанбаатар хот хүртэл 7000-8000 юань буюу 1 м³ ачаа 110-120 юанийн ханштай байгаа" гэсэн хариултыг албаныхан өгөв. Харин энэ талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт "Ачаа тээврийн үнэ буурснаар үнийн хөөрөгдлийн хөөс хагарна. Ковидын үед Эрэн-Улаанбаатарын хооронд нэг м.куб ачааны тээврийн хөлс 3000 юань хүрч тэнгэрт хадаж байсан. Дунджаар нэг чингэлэгт 64 м.куб ачаа ордог гэж үзвэл тухайн үеийн ханшаар тээврийн хөлс нь 192000 юань буюу 86 сая 400 мянган төгрөгт хүрч байв. Харин хил нээгдсэнээр Эрэн-Улаанбаатар хүртэлх

чингэлэг тээврийн хөлс өнөөдрийн ханшаар гурван сая 900 мянган төгрөг болж 20 дахин буураад байна. Өөрөөр хэлбэл, нэг м.куб ачаа Эрэн-Улаанбаатар хот хүртэл одоо 112 юанийн ханштай байгаа нь цар тахлын өмнөх үеэс 50 хувь буурсан гэсэн үзүүлэлт юм. Учир нь 2019 оны есдүгээр сард тээврийн үнэ ханш Эрэн-Улаанбаатарын хооронд нэг м.куб нь 220-250 юань байжээ" хэмээн цахим хуудсанд бичжээ. Харин энэ талаар худалдаа эрхлэгч Д.Ариунжаргалаас тодруулахад "Бид үнэ нэмэхгүй аль болох барьж худалдаалахыг хичээж байгаа. Гэхдээ үнэ буурахгүй байх эхний шалтгаан нь гаалийн татвар өссөн. Сахангааль дээр бүх ачааг задалж тоолоод ширхэг бараа бүрд татвар ногдуулах тухай яриа үнэний ортой юм шиг байна лээ. Мөн доллар, юанийн үнэ өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Байнгын өсөлттэй байгаа. Тиймээс шилжүүлэг өндөр тооцогдож байна. Энэ мэтээр үнэ буурахад олон хүчин зүйлийн нөлөө орж байгаа байх" гэв.

С.ОТГОНБАЯР

Монгол Улсад сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ой өчигдөр тохиолоо

Монгол Улсад үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ой өчигдөр тохиолоо. Тэртээ 1913 оны гуравдугаар сарын 6-нд "Шинэ толь хэмээх бичиг" сонин анхны дугаараа гаргасан нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны суурь байв. Энэхүү сонин эрхлэгчээр их соён гэгээрүүлэгч Жамсрангийн Цэвээн ажиллаж байсан бөгөөд түүнийг Монголын сэтгүүл зүйн салбарыг үндэслэгч хэмээн түүхэн эх сурвалжууд үздэг. Харин энэ өдрийг 1993 онд болсон сэтгүүлчдийн их хурлаар дэмжиж "Сэтгүүлчдийн өдөр" болгосон байдаг. Сэтгүүл зүйн анхны алхам болох "Шинэ толь сонин бичиг" 50 орчим хуудастай сэтгүүл хэлбэрээр 500 хувь хэвлэгдэж, Төрийн байгууллагуудад тараагддаг байсан түүхтэй. Цөөн хэдэн ширхгийг нь иргэдэд худалдаалдаг байсан нь түүхийн шаргал хуудаснаа бий.

ТОВЧХОН

Урсгал сөрөн хоёр хүүхэд гэмтээж, долоон машин мөргөсөн иргэн Ч.Маралмаагийн гэм бурууг шүүх хурал өчигдөр боллоо. Шүүхээс Ч.Маралмааг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг гурван жилээр хасах, зорчих эрхийг хоёр жилээр хязгаарлах, 1.7 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулав.

БНСУ-Д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэдийн хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэл энэ сарын 9, 10-нд явагдана.

Дархан-Уул аймагт иргэний удаа дараа зодож гэмтээсэн цагдаагийн хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Шинэ дугаар авах, эзэмшигчийн нэр шилжүүлэх гэх мэт бүртгэлтэй холбоотой ажиллагааг цахимжуулахаар төлөвлөж байгаа



»Турүүч нь / нүүрт»

Эхний ээлжид нийтийн тээврийн хэрэгсэл, төрийн байгууллагуудын тээврийн хэрэгсэлд төхөөрөмжөө уулгалаа. Тээврийн хэрэгслийн оношилгооны төвүүдээр өдөрт 2800 орчим тээврийн хэрэгсэл үзлэгт ордог. Үүн дээр тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн улсын хэмжээнд өдөрт 2300 орчим хийгддэг. Улсын хэмжээнд шүү дээ. Энэ үзүүлэлтийг харахад гурван сар орчмын хугацаанд бүрэн хүчин чадлаараа ажиллавал 400 мянган тээврийн хэрэгсэлд суурилуулах боломж байгааг ажлын хэсгээс тооцоолсон.

- Төхөөрөмж суулгах цэг шинээр байгуулах уу. Хаагуур суулгаж байна вэ?

- Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны төвүүд, бүртгэлийн байгууллагуудаар олгож эхэлнэ. Цаашид томоохон худалдааны төвүүдээр цахим гэрчилгээ олгохоор төлөвлөөд ажиллаж байна. Түүнчлэн орон нутгийн тээврийн цагдаагийн байгууллагуудтайгаа хамтраад ажиллахаар судалж байна. Орон нутгийн тээврийн хэрэгсэлд олгохоор тэр шүү дээ.

- Цахим гэрчилгээ заавал суулгах уу. Үүнд албадагын арга хэмжээ бий юу?

- Хуулиараа тээврийн

хэрэгсэл бүр улсын гэрчилгээтэй байх ёстой. Тээврийн хэрэгсэл бүр жилд нэг удаа техникийн хяналтад ордог. Тэгэхлээр цахим гэрчилгээ авна л гэсэн үг. Товчхондоо цаасан гэрчилгээний оронд цахим үнэмлэх авна л гэсэн үг л дээ.

- Цахим гэрчилгээ авахдаа торгуулиа төлсөн байх шаардлага тавьж байгаа юм билээ. Цаашид торгуультай тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцохгүй нь гэх ойлголт нийгэмд байна. Энэ талаар тодруулахгүй юу?

- RFID технологитой уялдуулан 15 байгууллагын 20-30 системийг нэгтгэсэн зам тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх болно. Энэ санд тээврийн хэрэгсэлтэй холбоотой бүх төрлийн мэдээллийг багтаах болно. Тодруулбал, техникийн хяналтын үзлэгт хамрагдсан эсэх, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, татвар, даатгал, торгуулиа төлсөн үү зэрэг бүх мэдээллийг энэ системээр хянах юм. Торгуули төлөөгүй бол замын хөдөлгөөнд оролцуулахгүй гэсэн журам одоогоор гараагүй. Цаашид гаргахаар бол нийтэд мэдээлэл өгөх болно. Энэ ажлыг ярихын өмнө эхлээд эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хэрэгтэй.

- Энэ мэт хувийн мэдээллийг хянахаар нөгөө талд байршлаас авахуулаад хүний хувийн мэдээлэл ил болно гэх шүүмжлэл байна. Үүнийг нэвтрүүлсэн улс орнуудад ямар байдаг юм бэ?

- Тээврийн хэрэгслийн байршил нь хувь хүн болоод байгууллагын нууцтай холбоотой асуудал. Мэдээллийг хянах байгууллагууд л хянана. Бид энэ системийг нэвтрүүлэхдээ Тагнуулын ерөнхий газар болон бусад байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа. Нийтийн зүгээс үүнд санаа зовох шаардлагагүй гэж ойлгож болно.

- Үүнийг цахим гэрчилгээ гэж нэрлэж байгаа. Жолооч цаг хэмнэх үүднээс онлайнаар үйлчилгээ авч болох нь?

- Бид шинэ дугаар авах, эзэмшигчийн нэр шилжүүлэх зэрэг тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг цахимжуулахаар төлөвлөж байгаа. Зам, тээврийн хөгжлийн яам 2023 онд иргэдэд үйлчилгээг хурдан шуурхай, хялбар байдлаар хүргэхийн тулд бүх үйл ажиллагаагаа цахимжуулах жил болгон зарласан. Үүний суурь дэд бүтэц нь RFID технологи гэж ойлгож болно.

О.ДАШ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Автомашины дугуй худалдан авах
Тендер шалгаруулалтын дугаар: ЗГАБ/202301004
Засгийн газрын автобааз ТӨААТҮГ нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг "Автомашины дугуй худалдан авах" тухай тендер ирүүлэхийг урьж байна.
Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Тийм Багц № 1: Том оврын автомашины дугуй худалдан авах Багц № 2: Жижиг оврын автомашины дугуй худалдан авах**
Сонирхох этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.
Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба

Багц №1: 191,000 /Нэг ерин нэгэн мянгал/ төгрөг
Багц №2: 171,000 /Нэг зуун далан нэгэн мянгал/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг 2023 оны 04 сарын 07-ны 10.00 цагаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлж ба тендерийн нээлтийг 2023 оны 04-р сарын 07-ны өдрийн 10:30-т зохион байгуулна.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: Үгүй
Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.
Монгол Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 6-р хороо Их тойруу, Баянбүрдийн зүүн тал Засгийн газрын автобааз ТӨААТҮГ өөрийн байр.
Хүний нөөцийн менежер Ш.Даваасүрэн
Утас: 80038403 Цахим хаяг: tender.gov.mn

Invitation for Bids (IFB)

CB No: MON16001
December 28, 2022
Mongolia

Procurement of the Modernization of National Central Archives of Mongolia
The establishment of Modernization of National Central Archives of Mongolia Project that consist of development of the Central Archives Management System (CAMS) and Portal System, Remodeling of the General Authority for Archives (GAA) building, Improvement of Preservation environment, and Digital Archive Center,

- The Government of Mongolia has received a Loan from the Export-Import Bank of Korea from the resources of the Economic Development Cooperation Fund (EDCF) of the Republic of Korea in the amount of Nineteen Million (19,000,000) USD (United State Dollars) toward the cost of "Modernization of National Central Archives of Mongolia" and intends to apply a portion of the proceeds of this loan to payments under the contract for the Procurement of the Modernization of National Central Archives of Mongolia.
- The Project Executing Agency now invites sealed bids from eligible bidders for the establishment of Modernization of National Central Archives of Mongolia Project that consist of development of the Central Archives Management System (CAMS) and Portal System, Remodeling of the General Authority for Archives (GAA) building, Improvement of Preservation environment, and Digital Archive Center, conducting the related services.
Loan Agreement Number: MON-16
- Bidding will be conducted through Competitive Bidding (CB) procedures specified in the Guidelines for Procurement under the EDCF Loans, and is open to all eligible bidders that meet the following minimum qualification criteria.
The Bidder may be a sole entity or a Joint Venture or Association (JVA):
(i) The sole entity or all partners of the JVA must have nationality of the Republic of Korea.
(ii) The sole entity or all partners of the JVA shall have a minimum of Five (5) year's business experience related to components of the Project from the issuing date of the IFB.
(iii) The sole entity or at least one partner of the JVA shall have at least One (1) successfully completed ICT project experience with a contract amount of more than Nine Million (9,000,000) USD. The project experience must be within Ten (10) years from the issuing date of the IFB.
(iv) The sole entity or at least one partner of the JVA shall have at least One (1) successfully completed Archive project experience with contract amount of more than One Million (1,000,000) USD. The project experience must be within Ten (10) years from the issuing date of the IFB.
(v) The sole entity or at least one partner of the JVA shall have at least One (1) successfully completed Building Construction and or Building Remodeling project experience with contract amount of more than One Million (1,000,000) USD. The project experience must be within Ten (10) years from the issuing date of the IFB.
(vi) The sole entity or all partners of the JVA shall have positive in its net worth calculated as the difference between total assets and total liabilities for the last Three (3) years (2019 - 2021) respectively.
(vii) All pending litigation shall be treated as resolved against the sole entity or each partner of the JVA and so shall in total not represent more than Fifty percent (50%) of the sole entity or each partner of the JVA net worth.
In case of JVA, the participating shareholding ratio of all partners of JVA must be mentioned in the JVA Agreement and the participating shareholding ratio for Leading partner of JVA shall not be less than Fifty percent (50% ≤ X). Bidders shall provide Technical responsiveness checklist and relevant documentary evidence to prove their qualification with the Technical proposal.
- Interested eligible Bidders may obtain further information from and inspect the bidding documents at the Project Implementation Unit Office at the address given below from 09:00 to 15:00 hours (Ulaanbaatar time GMT +8 hours), Monday to Friday for Twenty-one (21) calendar days prior to the bid submission date.
- A complete set of bidding documents may be purchased by any interested Bidders on the submission of an electronic application to the address below and upon payment of a nonrefundable fee of Five Hundred (500) USD. Bidder must present payment receipt to the procurement_mon16@mohja.gov.mn, procurement.mon16@gmail.com addresses. After payment confirmation, Bidding document will be delivered within Two (2) working days.
The method of payment can be remitted to a bank account below:
- Bank Name: STATE BANK OF MONGOLIA, ULAANBAATAR, MONGOLIA
Bank Address: 2nd Floor, Altai Building, Chinggis Avenue, 1 Khoroо, Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongolia
Account Name: MINISTRY OF FINANCE
Swift Code: STBMMNUJ
Account Number: 106000079576
- Correspondent bank: KOOKMIN BANK
Swift code: CZNBK33E
Account Number: 7968USD019
- Bids must be delivered to the address below at or before 11:10 AM (Ulaanbaatar time GMT +8 hours) on April 17, 2023. All bids must be accompanied by a bid security of Five Hundred Thousand (500,000) USD. Late bids shall be rejected. Bids will be opened in the presence of Bidders' representatives who choose to attend at the address below at 11:40 AM (Ulaanbaatar time GMT +8 hours) on April 17, 2023. The attention of prospective Bidders is drawn to (i) the fact that they will be required to certify in their bids that all software is either covered by a valid license or was produced by the Bidder and (ii) that violations are considered fraud, which is, among other remedies, punishable by potential blacklisting from participation in future EDCF-financed procurements.

Ministry of Justice and Home Affairs
Nominusudv Batsaikhan, Procurement Officer
Government building V, 8/4, B. Shirendev street, Bagu toriuru, 1st Khoroо, Chingeltei district,
Ulaanbaatar, Mongolia 15160
+ 976 95376408
procurement_mon16@mohja.gov.mn, procurement.mon16@gmail.com